

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны
даргын 2015 оны ... дугаар даргын ...-ны өдрийн
... дугаар хамтарсан тушаалын хавсралт

**ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН
ДААТГАЛЫН САНГ БҮРДҮҮЛЭХ, БАЙРШУУЛАХ,
ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 27.1-д заасан давхар даатгалын компани /цаашид “давхар даатгагч” гэх/-ийн малын индексжүүлсэн даатгалын сан (цаашид “нөөц сан” гэх)-г бүрдүүлэх, байршуулах, зарцуулах болон түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нөөц сан

2.1. Давхар даатгагч нь дараах нөөц сантай байна:

2.1.1. Хуулийн 27.1.1-д заасан дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан;

2.1.2. Хуулийн 27.1.2-г заасан дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан;

2.1.3. Хуулийн 27.1.3-г заасан алдагдлаас хамгаалах сан.

2.2. Энэ журмын 2.1-д заасан нөөц сангуудыг давхар даатгагчийн санхүүгийн тайлан балансынёр төлбөрийн хэсэгт тусгана.

Гурав. Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан

3.1. Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээг “ $N \geq M - X \text{ЭС}$ ” гэсэн томъёогоор тооцох бөгөөд эрсдэлийн дунд түвшний 15 жилийн дундаж хохирлын хэмжээнээс хамтын эрсдэлийн сангийн хариуцлагын хэмжээг хассандүнгээс багагүй байна.

3.2. Эрсдэлийн дунд түвшний 15 жилийн дундаж хохирлын дүн буюу “ M ”-ийг тооцохдоо “ $M = a * b * c$ ” гэсэн томъёогоор сум болон малын төрөл тус бүрээр бодож нийлбэрийг авна:

3.2.1. “ M ” – тухайн сумын малын төрөл тус бүрийн эрсдэлийн дунд түвшинд учирч болзошгүй хохирлын дүн;

3.2.2. “ a ” – тухайн сумын малын төрөл тус бүрийн эрсдэлийн дунд түвшинд сүүлийн 15 жилд хорогдсон том малын хорогдлын дундаж хувь;

3.2.3. “ b ” – тухайн сумын малын төрөл тус бүрийн малын индексжүүлсэн даатгалд тухайн борлуулалтын улиралд хамрагдсан хувь;

3.2.4. “с” – тухайн сумын малын төрөл тус бүрийн тухайн жилийн нийт үнэлгээ;

3.3. “ХЭС” буюу хамтын эрсдэлийн сан гэж хуулийн 4.1.13-т заасан санг ойлгоно.

Дөрөв. Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан

4.1. Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээ нь эрсдэлийн дээд түвшинд учирч болзошгүй хохирлын дүнгээс багагүй байна.

4.2. Эрсдэлийн дээд түвшинд учирч болзошгүй хохирлын дүн буюу “**L**”-ийг тооцохдоо “**L=d*b*c**” гэсэн томъёогоор сум болон малын төрөл тус бүрээр бодож нийлбэрийг авна:

4.2.1. “**L**”- тухайн сумын малын төрөл тус бүрийн эрсдэлийн дээд түвшинд учирч болзошгүй хохирлын дүн;

4.2.2. “**d**” – тухайн сумын малын төрөл тус бүрийн эрсдэлийн дээд түвшний сүүлийн 15 жилийн том малын хорогдлын дундаж хувь;

4.2.3. “**b**” – тухайн сумын малын төрөл тус бүрийн малын индексжүүлсэн даатгалд тухайн борлуулалтын улиралд хамрагдсан хувь;

4.2.4. “**c**” – тухайн сумын малын төрөл тус бүрийн тухайн жилийн нийт үнэлгээ;

Тав. Алдагдлаас хамгаалах сан

5.1. Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах сан нь дээд болон дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгө нь хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцэхгүй болсон тохиолдолд ашиглах зориулалт бүхий нөөц сан юм.

5.2. Давхар даатгагч нь алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулахад Хорооны 2008 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг дагаж мөрдөнө.

Зургаа. Нөөц санг бүрдүүлэх

6.1. Дунд түвшний эрсдэлээс хамгаалах санг даатгагчдаас төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн **цэвэр** орлогоос актуар аргачлалаар тооцож байгуулах бөгөөд энэ журмын 3.1-д заасан шаардлагад нийцүүлэн байгуулна.

6.2. Дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг Засгийн газраас төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн **цэвэр** орлогоос актуар аргачлалаар тооцож байгуулах бөгөөд энэ журмын 4.1-д заасан шаардлагад нийцүүлэн байгуулна.

6.3. Давхар даатгалын хураамжийн орлогоос олон улсын давхар даатгалын хураамжийг хасч хураамжийн цэвэр орлогыг тодорхойлно.

6.4. Олон улсын давхар даатгалын хураамжийг давхар даатгагч нь даатгагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн, эсвэл хэсэгчлэн олон улсын давхар даатгагчид дахин даатгаж төлсөн болон төлөхөөр тооцсон дүнгээр тодорхойлно.

6.5. Тухайн тайлант хугацаанд ногдох хураамжийн цэвэр орлогод давхар даатгагчийн үйл ажиллагааны зардал, ашиг багтана.

Долоо. Нөөц сангийн хөрөнгийг байршуулах, хөрөнгө оруулалт хийх

7.1. Давхар даатгагч нь энэ журмын 2.1.1 болон 2.1.2-т заасан нөөц сангуудын хөрөнгийг энэ журамд заасны дагуу байршуулж, хөрөнгө оруулалт хийх бөгөөд алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийг байршуулах, хөрөнгө оруулалт хийхдээ энэ журмын 5.2-т заасныг баримтална.

7.2. Давхар даатгагч нь нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхдээ учирч болох дараах эрсдэлүүдийг тооцоолно:

7.2.1. Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл хамаарна.

7.2.2. Авлагын эрсдэл. Үнэт цаас гаргагч, харилцагч түнш болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн байдал муудах үүнээс болж үнэт цаас хугацаандаа төлөгдөөгүйн улмаас даатгагч санхүүгийн хохирол амсах эрсдэлтэй. Энэ төрлийн эрсдэлд үнэт цаас төлөгдөхгүй байх, үнэт цаас гаргагчийн үнэлгээ буурах зэрэг эрсдэлүүд орно.

7.2.3. Хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл. Даатгуулагчдад их хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгох шаардлагатай тохиолдолд даатгагчийн хөрөнгийн хөрвөх чадвар хүрэлцэхгүйн улмаас бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэлтэй. Ийм төрлийн эрсдэлд хөрвөх чадварын үнэлгээний эрсдэл, салбаруудад оруулсан хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл, хөрөнгийн сангийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

7.3. Давхар даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь зөвхөн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаар баталсан нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх бөгөөд уг төлөвлөгөөнд энэ журмын 7.2-т заасан эрсдэлийг удирдах бодлого, стратегийг тусгаж, хэрэгжүүлнэ. Мөн нөөц сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг давхар даатгагчийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан байна.

7.4.Нөөц сангийн хөрөнгөөр Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас гадна дараах этгээдэд хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлах бөгөөд энэхүү этгээд нь нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд эрсдэл бүхий этгээдэд тооцогдоно:

- 7.4.1. Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээд;
- 7.4.2. Давхар даатгагчийн болон холбогдох этгээдийн хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;
- 7.4.3. Давхар даатгагчийн хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;
- 7.4.4. Холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;
- 7.4.5. Даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

7.5. Давхар даатгагч нь ТУЗ-ийн хурлаар баталсан төлөвлөгөөний дагуу нөөц сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх бөгөөд энэ журмын 7.6-д заасан шаардлагад нийцүүлнэ.

7.6. Нөөц сангийн хөрөнгийг байршуулах, хөрөнгө оруулалт хийхдээ дараах ангилал, хэмжээ хязгаарт нийцүүлнэ:

Хөрөнгийн ангилал		Хөрөнгө оруулах дээд хувь
7.6.1.Засгийн газрын бонд		100%
7.6.2.Төв банкны үнэт цаас /Монгол банкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг ойлгоно/		100%
7.6.3.Банкны хадгаламж		100%
7.6.4.Банкны хадгаламжийн сертификат		50%
7.6.5.Санхүүгийн түрээс/Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1, 3.2-т заасныг ойлгоно/		10%
7.6.6.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг ойлгоно/		60%
7.6.7.Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно/		20%
7.6.8.Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл		60%
7.7.9.Компанийн өрийн хэрэгсэл		20%
7.6.10.МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	7.6.10.а. I ангилал	10%
	7.6.10.б. II ангилал	5%
7.6.11.Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах		20%

банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	
Нөөцсангийн нийтхөрөнгөөсдотоодод хийххөрөнгөоруулалтындээд хэмжээ	100%

7.7. Нөөц сангийн хөрөнгийн нийт дүнгээс хөрөнгө оруулалт хийсэн дүнг хассан үлдэгдэл нь мөнгөн хөрөнгөөр байршина.

7.8. Энэ журмын 7.6, 7.7-д зааснаас бусад ангиллаар нөөц сангийн хөрөнгийг байршуулах, хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.

7.9. Нөөц сангаас хөрөнгө оруулах дүнг тооцохдоо нөөц сангийн хөрөнгийн дүнг харгалзах хөрөнгө оруулах хувиар үржүүлж тооцно.

7.10. Давхар даатгагч нөөц сангийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын тайлангаа энэ журмын 1 дүгээр хавсралтын “Маягт-1”-ээр гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

Найм. Нөөц санг зарцуулах

8.1. Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан нөөц сангуудын хөрөнгийг зөвхөн малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрт зарцуулна.

8.2. Энэ журмын 2.1.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг эрсдэлийн дунд түвшинд тус нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын дүнгээр зарцуулна.

8.3. Энэ журмын 2.1.2-т заасан нөөц сангийн хөрөнгийг эрсдэлийн дээд түвшинд тус сангаас нэхэмжилсэн хохирлын дүнгээр зарцуулна.

8.4. Малын индексжүүлсэн даатгалын нийт нэхэмжилсэн хохирлыг ХЭС, энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан нөөц сангууд болон олон улсын давхар даатгагчаас төлж хүрэлцэхгүй болсон тохиолдолд зөрүүг алдагдлаас хамгаалах сангаас олгоно.

8.5. Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан нөөц сангуудын тухайн тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь дараагийн тайлант хугацааны эхний үлдэгдэл болно.

Ес. Нөөц санд тавих хяналт

7.1. Давхар даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд даатгалын бүх нөхөн төлбөрийг олгож, хураамжийн буцаалт хийгдсэний дараах нөөц сангийн үлдэгдлийг Компанийн тухай хуульд заасны дагуу хуваарилна.

7.2. Давхар даатгагч нь нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг гаргаж, улирал тутам Хороонд ирүүлнэ.

7.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---